

ГАРЧИГ

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	2
1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ	2
1.2. ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА ГОЛ ШААРДЛАГА	2
1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	2
1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	2
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	5
4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	6
5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	7
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	8
7. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 10	
8. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө 11	

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Жил бүр хийгдэх ОХШ-ний мониторингийн цэгүүдийн координат	3
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4
Хүснэгт 3. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	5
Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	8
Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10
Хүснэгт 8. БОМТ-ний биелэлтийг олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	11
Хүснэгт 9. 2026 оны БОМТ-ний зардал, мян.төг	12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Жил бүр хийгдэх ОХШ-ний мониторингийн цэгүүдийн байршил	3
--	---

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Мөнх Тэнүүн Оргил ХХК-ийн Кокс-химийн үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Мөнх Тэнүүн Оргил ХХК-ийн Кокс-химийн үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах үүрэгтэй.

Улмаар батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Баян-Овоо сумын ЗДТГ-т танилцуулан, 12 дугаар сард багтаан АБОГ-т хүргүүлж, дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг БОУАӨЯ-аар батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг эхний таван жилээр тооцсон болно.

1.2. ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА ГОЛ ШААРДЛАГА

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн үнэлгээний журам, А/117-р ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн


**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 1. Жил бүр хийгдэх ОХШ-ний мониторингийн цэгүүдийн координат

Шинжилгээний нэр	X	Y
Цацрагийн шинжилгээний мониторингийн цэг	106.055285	43.335686
Цацрагийн шинжилгээний мониторингийн цэг	106.048478	43.33841
Цацрагийн шинжилгээний мониторингийн цэг	106.0473	43.337763
Агаарын шинжилгээний мониторингийн цэг	106.047798	43.338862
Агаарын шинжилгээний мониторингийн цэг	106.053	43.336248
Агаарын шинжилгээний мониторингийн цэг	106.050644	43.335973
Агаарын шинжилгээний мониторингийн цэг	106.052342	43.338785
Дуу чимээний шинжилгээний мониторингийн цэг	106.051821	43.337003
Дуу чимээний шинжилгээний мониторингийн цэг	106.047134	43.338713
Усны шинжилгээний мониторингийн цэг	106.050222	43.336167
Усны шинжилгээний мониторингийн цэг	106.050222	43.337972
Усны шинжилгээний мониторингийн цэг	106.052556	43.337972
Усны шинжилгээний мониторингийн цэг	106.054028	43.333603
Хөрсний шинжилгээний мониторингийн цэг	106.048586	43.336013
Хөрсний шинжилгээний мониторингийн цэг	106.050586	43.337306
Хөрсний шинжилгээний мониторингийн цэг	106.047414	43.337906



Зураг 1. Жил бүр хийгдэх ОХШ-ний мониторингийн цэгүүдийн байршил

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	2	3	4	5	6	7	8
Агаарын бохирдлыг бууруулах	Төслийн зөвшөөрөлтэй талбайн хилийн дагуу салхинаас хамгаалах хашаа бий болгох	Төслийн талбайд	м	Зураг төсөл	535.5	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр	2026
Хөрсний бохирдлыг бууруулах	Байнгын ашиглагдах замыг хатуу хучилттай болгох		км	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр	1.7	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр	2026
	Нүүрс ачих, буулгах талбайг хатуу хучилттай болгох		га	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр	8.3	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр	2026
Усны бохирдлоос сэргийлэх	Худаг уст цэгийг барилгыг засан сайжруулж, тэмдэгжүүлэх	Худаг уст цэг орчимд	ш	60.0	4	240.0	2026
	Төслийн талбайн гадна байрлах 1 худаг уст цэгийг хашаажуулж хамгаалах		м	20.0	40	800.0	2026
	Ус ашигласны төлбөр төлөх		-		Тооцооллоор гарсан дүнгээр		
Нийт зардал				5000,0			

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд салхинаас хамгаалсан хашаажуулалт, хүнд даацын машин хатуу хучилттай зам талбай, ногоон байгууламж, нэгдсэн хогийн цэг, байгальд ээлтэй био-жорлон, шингэн хог хаягдлын нүхэн байгууламж зэргийг шинэчлэн орчны тохижилтыг сайжруулах төдийгүй сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой төлөвлөсөн байна. Мөн Эдэлбэр газрын ЭЭЗҮ-ийн дүнгээр 15,340,800 төгрөгийн үнэлгээ бүхий нөхөн сэргээлтийн зардал тооцно.

Хүснэгт 3. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давамж
1	2	3	4	5	6	7	8
Хөрсөн бүрхэвчийг хамгаалж ногоон байгууламж бий болгох	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд болон орчны тохижилтод зориулж бургас мод тариx;	Төлөвлөсөн талбайд	ш	1700	1020.0	1020.0	Жил бүр 340 ш мод шинээр суулгаж, тарина
	Өмнө жилүүдэд тарьсан ногоон байгууламжийг арчлах, тордох	Мод тарьсан талбайд	м ²	2200	Дотоод зардлаар тооцох		Төсөл хэрэгжих хугацаанд
Нөхөн сэргээлтийн зардал	Эвдэрсэн талбайг нөхөн сэргээх		га	14	3068,16		Төсөл хэрэгжих хугацаанд
Нийт зардал					4088,16		

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	2	3	4	5	6	7
Газар хөдлөлт	Ажилчид газар хөдлөлт болон онцгой байдлын үед цугларах талбайг тэмдэгжүүлж	Төслийн талбайд	1	Самбар - 60.0	60.0	2026
	Суурь дуут дохионы систем суурилуулах		1	6000.0	6000.0	2026
Хүчтэй шороон шуурга	Ажилчдад нүдний шил, амны хаалтаар тогтмол хангах	Төслийн талбайд	-		1000.0	2026
Гал, түймрийн аюул, осол	Ажиллагсдад ХАБ-ын болон гамшгийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх иж бүрэн сургалтын хөтөлбөр болон дасгал сургуулилалт зохион байгуулж хамруулах		Бүх ажилчдад	Жилд 500.0	500.0	ХАБ-ын сургалтын сард 2 удаа, гамшгаас хамгаалах сургалт, дасгал сургуулилалтыг улиралд 2 удаа зохион байгуулах
Цахилгаан тог хүчдэлийн эрсдэл	Барилга объектод цахилгааны газардуулга хийх		1	900.0	900.0	2026
Машин техникийн аваар осол	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй бүх төрлийн тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулах, тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын алба журмын даатгалд хамруулах		Иж бүрэн	Нарийвчилсан судалгааны үнэлгээгээр		2026
Нийт зардал				8460,0		

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж
1	2	3	4	5	6	7	8
Хатуу хог хаягдал	Битүүмж сайтай болгож хогийн цэгийг тохижуулах, суурийг цементлэх, хог хаягдлыг ялган ангилах зорилгоор тусгаарлалттай болгох	Хогийн цэгийн талбайд	Зураг төсөл		100 м ² талбайд тохижуулалт хийх зардал ойролцоогоор 5		2026
	Хог хаягдлыг ялган хаях зорилгоор хогийн сав байршуулах	Ажилчдын кемп, оффис, гал тогоонд	ш	12	190.0	2280.0	2026
	Хог тээврийн гэрээнд заасан хугацаанд хог хаягдлыг зайлуулах	Төслийн талбайд	Жилд		108,3	1300.0	Сар бүр
Хог хаягдлыг бүртгэх, тайлагнах	Сар бүр тайлан мэдээ боловсруулж, жил бүр сумын Засаг даргат тайлан хүргүүлэх	Төслийн хүрээнд	ш	Сар бүр 1 удаа мэдээ бүртгэх, Жилд 1 тайлан гаргах	100.0	100.0	2026
Нийт зардал					3680,0		

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тус үйлдвэр нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа орчны хяналт шинжилгээг тогтсон цэгээс, тогтмол хийж шинжилгээний үр дүнгээс шалтгаалж, урьдчилан сэргийлэх болон сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Жил бүр 16 мониторингийн цэгээс 10 төрлийн хяналтын шинжилгээ хийх хөтөлбөрийг боловсруулан урьдчилсан төсвийг 5 жилийн хугацаагаар тусгав.

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Шинжилгээ авах цэгийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт
1	2	3	4	5	6	7	8
Агаарын бохирдол	Нүүрс ачих буулгах болон тээвэрлэлтийн зам орчимд	Жилд 1 удаа 5 жилд 5 удаа	4	50.0	200.0	Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO	“Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага” MNS
						Хүхрийн давхар исэл, SO2	
						Азотын ислүүд, NOx	
						Нийт тоос, TSP	
Дуу чимээний бохирдол	Үйлдвэрийн хэсгээс		2	40.0	80.0	Дуу чимээ	4585:2016
Хөрсний бохирдол	Хогийн цэг орчим		1	45.0	45.0	Хром, Cr	“Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019
						Хар тугалга, Pb	
						Кадми, Cd	
						Никель, Ni	
						Цайр, Zn	
		Зэс, Cu					
Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хогийн цэг орчим	50.0	50.0	Цэвэр	“Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019		
				Бохирдол багатай			
				Дунд зэргийн бохирдолтой			
Хөрсний агрохимийн найрлага	Төслийн талбайн гадна болон дотор хэсгээс	2	50.0	100.0		pH	
						Ялзмаг, %	
						Давс, %	
					ЦДЧ, dS/m		
					NO3, мг/л		
Хөрсний механик бүрэлдэхүүн		50.0	100.0	Элс			
				Тоос			
				Шавар			
Усны чанар, ундны усны бүрэн шинжилгээ	Худгийн уснаас	4	35.0	140.0	Бохирдол багатай	“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй	
					Дунд зэргийн бохирдолтой		
					Их бохирдолтой		

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Шинжилгээ авах цэгийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт
1	2	3	4	5	6	7	8
						Сульфатын ион / 500.0мг/л Кальцийн ион / 100.0мг/л Магнийн ион / 30.0мг/л Натри ион / 200.0мг/л Хуурай үлдэгдэл / 1000.0мг/л	байдлын үнэлгээ” MNS 0900:2005
Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерын тоо				35.0	140.0	Цэвэр Бохирдол багатай Дунд зэргийн бохирдолтой Их бохирдолтой	
Ундны усан дахь хүнд металлын агууламж				35.0	140.0	Хүнцэл, As Хром, Cr Зэс, Cu	
Үйлдвэрт ашиглагдах түүхий эдээс цацрагийн шинжилгээ тогтмол авах	Түүхий эд буулгах талбай	Түүхий эд татах бүрд	3	50.0	150.0	Гамма цацрагийн хувийн идэвхийг тодорхойлох шинжилгээ	MNS 5072:2018, MNS 5626: 2006
Нийт зардал			16		1895.0		

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

7. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
		2026 он				
		I	II	III	IV	
1	2	3	4	5	6	7
БОМТ-г тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулах	1500.0	+			+	Менежер
Газрын төлөв байдлын хянан баталгааны дүгнэлт гаргуулах	5000.0			+		Менежер
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, эмийн сан, гал унтраах хэрэгсэл бэлэн байлгах	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд туссан зардлаар					Менежер
Байгалийн гамшиг болон гэнэтийн осол, аваараас урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр болон дасгал сургуулилалт зохион байгуулж хамруулах		+			+	Менежер
Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулах		+				
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдах ажилд идэвх санаачилгатай оролцох	Орчны тохижилтын төлөвлөгөөнд туссан зардлаар		+	+		Менежер
Нийгмийн хариуцлагын хүрээнд сум, багаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцох	Дотоод зардлаар	+	+	+	+	Менежер
Ус ашиглуулах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Гэрээнд зааснаар	+			+	Менежер
Усны нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын хэмжээнээс хамаарч жил бүр төлөх	Ус ашиглалтын хэмжээгээр				+	Менежер
Ус ашиглалтын тайланг 12 дугаар сарын 20-ны дотор багтаан АБОГ-т хүргүүлэх	Үйл ажиллагааны зардлаар				+	Менежер
Холбогдох гэрээнүүдийг хугацаанд нь сунгаж байх	-					Менежер
Хог хаягдлын тайланг сумын Засаг даргат хүргүүлэх	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардлаар				+	
Тохижилтын бүх ажлууд, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээнүүд	-		+	+		
Бусад шаардлагатай арга хэмжээ	Магадалшгүй зардлаар					Менежер
Нийт зардал	6500.0					

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

8. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ-г боловсруулах болон тайлагнах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу тэднийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагын саналыг тусгах зорилготой юм.

Хүснэгт 8. БОМТ-ний биелэлтийг олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ-г хэлэлцүүлэх оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
Холбогдох албан тушаалтан	Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх, санал авах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах, биелэлт тайлагнах	Жил бүрийн X сард	Менежер	Төсөл хэрэгжиж буй хорооны Иргэний танхимд
Орон нутгийн иргэд, хорооны ИНХ					
Шаардлагатай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны төрийн бус байгууллага		Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил			Компанийн байранд
Нийт зардал					500,000

**ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “КОКС-ХИМИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хүснэгт 9. 2026 оны БОМТ-ний зардал, мян.төг

№	Ажлын чиглэл	Хийгдэх ажлын тоо	Төсөв, мян.төг/он
			2026
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8	5160.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3	4088.16
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	9	2060.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4	3680.0
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	13	750.0
6	БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах	3	500.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10	1895.0
	Нийт төсөв (мян.төг)	50	30123.16